

Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн төлөв байдал, бүтээмжийн судалгаа, дүгнэлт

Research on Financial Condition and Productivity of Business Entities in Mongolia

Л. Наранчимэг¹

Хураангуй

Монголын Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн өнөөгийн төлөв байдлыг СнЯ-ны нягтлан бодох бүртгэлийн газраас нэгтгэн гаргадаг “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл”-ийн тоо мэдээ болон статистикийн мэдээлэлд тулгуурлан судалж нийт аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн болон хөдөлмөрийн бүтээмжийн өнөөгийн төлөв байдал, хөгжлийн төлөв хандлага, онцлогийг тодорхойлж судалгааны эргэлтэнд оруулах, улмаар тайлангийн мэдээллийн үнэн зөв, нээлттэй байдлыг хангахад Нягтлан бодох бүртгэл, тайлагналын үүргийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт гаргахыг зорьсон болно.

Түлхүүр үгс: бизнесийн байгууллага, нийт хөрөнгийн хэмжээ, борлуулалтын орлого, дотоодын нийт бүтээгдэхүүн, дундаж цалин, хөдөлмөрийн бүтээмж

Abstract

The study aims to provide conclusion for increasing the role of accounting and reporting by ensuring the accuracy and transparency of reporting. The data is based on data of "summary of financial reporting of entities" which are consolidated by the Department of Accountancy at Ministry of Finance of Mongolia and statistical data. The study covers to review the current state of financial and labor productivity and to define its development trends, so that increase the role of accounting and reporting.

Keywords: business entities, total assets, sales revenues, GDP, average wages and productivity

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим, Доктор (Ph.D)
E-mail: naranchimeg_l@num.edu.mn

Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн төлөв байдлын судалгаа

Монгол Улсад үйл ажиллагаа явуулахаар бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо жилээс жилд дунджаар 5-11 хувиар нэмэгдэж байна. 2018 оны 2-р улирлын байдлаар нийт 163,100 аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ) бүртгэлтэй, үүний 51 хувь буюу 83,086 аж ахуйн нэгж л үйл ажиллагаа явуулж байна. Үлдэж байгаа аж ахуйн нэгжүүд нь (49 хувь нь) үйл ажиллагаа явуулаагүй, эрхлээгүй, түр зогсоосон, үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна (Хүснэгт 1).

2018 оны 2-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 4.4 хувь буюу 3,917 байгууллага нь ХАА-н салбарт, 8.8 хувь буюу 7,293 нь аж үйлдвэрийн

салбарт, 8.1 хувь буюу 6,760 нь барилгын салбарт, 39.1 хувь буюу 32,489 нь худалдааны салбарт, 39.3 хувь буюу 32,627 байгууллага нь үйлчилгээний салбарт тус тус үйл ажиллагаагаа явуулж байна (Зураг 1). Үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн 78.4 хувь буюу 65,116 ААНБ нь худалдаа үйлчилгээний чиглэлээр ажиллаж байна. 1-9 ажиллагчидтай ААНБ 85.8, 10-19 ажиллагчидтай 6.3 хувь, 20-49 ажиллагчидтай 4.9 хувь, 50-иас дээш ажиллагчидтай 3 хувийг тус тус эзэлж байна (Зураг 2). Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллагын дийлэнх нь буюу 86 орчим хувь 1-9 ажиллагчидтай худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байна.


ААНБ-ын санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “Аж ахуйн

Хүснэгт 1. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо


Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	2017	2018.II
Үйл ажиллагаа явуулж байгаа	54,929	59,843	64,301	72,182	78,585	83,086
Үйл ажиллагаа явуулаагүй	44,674	53,759	62,259	69,320	76,480	80,014
Үйл ажиллагаа эрхлээгүй	14,948	14,266	21,124	30,539	38,149	42,618
Үйл ажиллагаагаа түр зогсоосон	22,706	34,571	36,650	34,660	34,204	33,177
Үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон	706	1,750	1,626	1,527	1,570	1,625
Олдохгүй болон бусад	6,314	3,172	2,859	2,594	2,557	2,594
Бүгд	99,603	113,602	126,560	141,502	155,065	163,100

Эх сурвалж: 1212.mn


Зураг 1. Үйл ажиллагаа явуулж буй




Зураг 2. Ажиллагчдын тооны бүтэц



Зураг 3. ААНБ-ын нийт хөрөнгийн хэмжээ, хувиар



Зураг 4. ААНБ-ын борлуулалтын орлого, хувиар



нэгж, байгууллага нь улирал, жилийн санхүүгийн тайланг батлагдсан маягаар болон цахим хэлбэрээр энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад тушаана” гэсэн 12.2 дахь заалт болон Сангийн сайдын 2014 оны 242 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, мэдээллийг ашиглах журам”-ын 2.1 дэх заалт “Аж ахуйн нэгж, байгууллагын И-балансад шивсэн улирлын болон жилийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д заасны дагуу Сангийн яам, аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн мэргэжилтэн хянан, баталгаажуулж хүлээн авна” гэсний дагуу хүлээн авч баталгаажуулж байна.

Зураг 3 ба Зураг 4-өөс харахад 2016 оны байдлаар жижиг, дунд аж ахуйн нэгж буюу 100 сая төгрөг хүртэлх хөрөнгө, борлуулалтын орлоготой байгууллагын тоо нийт ААНБ-ын 79-85 хувийг эзэлдэг боловч нийт хөрөнгийн 6 хувийг эзэмшиж, борлуулалтын орлогын 15%-ийг бүрдүүлж, харин том аж ахуйн нэгжүүд тооны хувьд цөөхөн (14-21%) боловч хөрөнгийн 94%, орлогын 81%-ийг бүрдүүлж тэдгээрийн үүрэг оролцоо сүүлийн 5 жилд тогтвортой нэмэгдэх хандлагатай болжээ.

Нийт аж ахуйн нэгжийн 86 хувь нь 0-100 сая төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд байгаагаас үзвэл манай аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь жижиг нэгжүүд байна. Хөрөнгийн болоод борлуулалтын орлогын хувьд

Хүснэгт 2. Хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, 2013-2016, хувиар

Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	2013-2015 оны дундаж	
					х/жин	өсөлт, %
<i>Хөрөнгийн бүрэлдэхүүн</i>						
Эргэлтийн хөрөнгө	63.7	63.4	50.9	61.5	59.2	111.6
Эргэлтийн бус хөрөнгө	36.3	36.6	49.1	38.5	40.8	115.2
Нийт хөрөнгө	100.0	100.0	100.0	100.0	100.	112.9
<i>Санхүүжилтийн бүрэлдэхүүн</i>						
Богино хугацаат өр төлбөр	58.0	57.3	54.0	50.5	54.6	108.0
Урт хугацаат өр төлбөр	20.0	20.5	19.0	22.9	20.7	116.9
Нийт өр төлбөр	78.0	77.8	73.0	73.4	75.3	110.5
Эздийн өмч	22.0	21.2	27.0	26.6	24.7	120.9
Нийт эх үүсвэр	100.0	100.0	100.0	100.0	100.0	112.9

Эх сурвалж: СНЯ “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн нээлтгэл 2011- 2016”

жигжиг аж ахуйн нэгжүүдийн хувийн жин 2007-2015 онд буурч, дунд болон томоохон нэгжүүдийн хувь оролцоо өсөх хандлагатай болжээ.

ААНБ-ын сүүлийн 4 жилийн дунджаар тооцоход нийт хөрөнгийн 59.2 хувийг эргэлтийн хөрөнгө, 40.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж, сүүлийн жилүүдэд (2013-2016 онд) эргэлтийн хөрөнгийн эзлэх хувийн жин буурах хандлагатай байгаа нь хөрөнгийн хөрвөх чадвар болон эргэцэд сөрөгөөр нөлөөлсөн байна (Хүснэгт 2).

2011 оноос хойш ААНБ-ын нийт хөрөнгө 42,806 тэрбум төгрөгөөс 121,639 тэрбум төгрөг болж бараг 3 дахин өссөн ба 2015 онд гэхэд л өмнөх оноос 29,450 тэрбум төгрөг буюу 24 хувиар өссөн байна. Гэхдээ хөрөнгийн зонхилох өсөлт 2012-2013 онд бий болсон (нийт хөрөнгө 73.5 хувиар, үүнээс эргэлтийн хөрөнгө 132.7 хувиар өссөн) бөгөөд дараагийн онуудад өсөлт тогтворжиж, 2015 онд эргэлтийн бус хөрөнгө огцом нэмэгдсэн (77.0 хувиар) нөхцөл байдлыг харгалзан 2013-2016 оны дундажаар тооцоход нийт хөрөнгийн 59.8 хувийг эргэлтийн, 40.2 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж, эргэлтийн бус хөрөнгө жил тутам 45 хувиар нэмэгдэж, өсөлт нь давамгайлж ирсэн ч 2016 онд буурчээ.

2016 оны гүйцэтгэлээр санхүүжилтын 73.0 хувийг өр төлбөр, 27.0 хувийг өөрийн хөрөнгө эзэлж, нийт санхүүжилтанд өөрийн хөрөнгийн оролцоо сүүлийн 3 жил дараалан нэмэгдсэн байна. ААНБ-ын нийт өр төлбөрийн 74 хувийг богино хугацаат өр төлбөр, 26 хувийг урт хугацаат өр төлбөр бүрдүүлж, харин Засгийн газрын өрийн 43.3 хувийг богино хугацаат өр төлбөр, 56.7 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Сүүлийн 3 жилийн дундажаар тооцоход

ААНБ-ын нийт хөрөнгийн санхүүжилтын 3/4 буюу 76 хувийг урт ба богино хугацаат өрөөр, 24 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж, өөрийн хөрөнгийн өсөлт илүү хурдацтай байгаа нь (138.5% > 120.6%) сайшаалтай юм.

Аливаа бизнесийн байгууллагын үйл ажиллагааны далайц, өсөлтийн чиглэлийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрөл, борлуулалтын орлогод тэдгээрийн эзлэх хувийн жингээр тодорхойлохоос гадна эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн динамик шинжилгээг тодорхой эрэмбэ дарааллаар нь хийх нь арга зүйн хувьд зохимжтой байдаг. Хөрөнгө эх үүсвэрийн бүтэц бүрэлдэхүүн, тэдгээрийн өсөлтийн хурд буюу үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн нормативт харьцаа нь $ӨК > ЭБ > НХ > ЭХ > ГК$ байвал зохимжтой гэж Оросын эрдэмтэд тодорхойлжээ. Тэгэхдээ өсөлтийн харьцааны норматив нь санхүүгийн тогтвортой байдлын өнцөгөөс харсан хамаарал бөгөөд оруулсан хөрөнгийн ашиглалт өгөөжийн талаас нь үзвэл өөр байж болох талтай. Өсөлтийн харьцааг зэрэгцүүлэхдээ зөвхөн тайлант оных төдийгүй өмнөх 3-5 жилийн дундаж өсөлтөөр нь тооцвол ерөнхий дүр зураг харагдах боломж илүү байж болох юм.

Санхүүгийн тайлангийн нэгтгэл буюу нийт ААНБ-ын дүнгээр болон компаниудаар тооцоолоход үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн харьцаа нь төдийлэн ялгагдахааргүй $ЭБХ > ӨК > НХ > ГК > ЭХ$ болж үзүүлэлт тус бүрийн өсөлтийн зэрэглэл нормативаас нилээд өөр, тухайлбал эргэлтийн бус хөрөнгийн өсөлт давамгайлсан, тэр өсөлтийн багагүй хэсгийг өөрийн хөрөнгө (эздийн өмч)-ийн өсөлтөөр хангасан нийтлэг дүр зэрэг харагдаж байна. Энэ нь зөвхөн

Хүснэгт 3. ААНБ-ын үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд

Үзүүлэлтүүд		Өөрийн хөрөнгө	Эргэлтийн бус хөрөнгө	Нийт хөрөнгө	Эргэлтийн хөрөнгө	Нийт өр төлбөр
Нормативт зэрэглэл (R)		1	2	3	4	5
Тайлангийн нэгтгэлээр	2016 оны өсөлт, бууралт	92.1 (4)	72.7 (5)	93.1 (2)	111.8 (1)	92.7 (3)
	Өнгөрсөн 4 жилийн дундаж өсөлт	120.9 (1)	115.2 (2)	112.9 (3)	111.6 (4)	110.5 (5)
ХК болон ХХК-иудаар	2015 оны өсөлт, бууралт	162.7 (2)	178.6 (1)	145.0 (3)	112.3 (5)	138.3 (4)
	Өнгөрсөн 3 жилийн дундаж өсөлт	138.1 (2)	144.4 (1)	130.4 (3)	115.2 (5)	127.4 (4)

Эх сурвалж: Судлаачийн тооцооноор

компаниудад төдийгүй санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдсан нийт ААНБ-уудад түгээмэл байна. 2015 оны гүйцэтгэл болон 2013-2015 оны дундаж өсөлтийн хувь хэмжээ нь ялгаатай хэдий ч ерөнхий хандлага нь ялгагдахаагүй гарсан нь өнгөрсөн 3 жилийн дундаж өсөлтөнд 2015 оны гүйцэтгэлийн өсөлтийн нөлөөлөл их байсантай холбоотой юм (Хүснэгт 3).

Эдгээрээс ерөнхийд нь дүгнэвэл ААНБ-уудын нийт санхүүжилтын 70 гаруй хувийг өр төлбөрөөр нөхөж байгаа хэдий ч бизнесийн хөрөнгө оруулалтын өсөлтийг хангахад гадаад эх үүсвэрийн тэр дундаа урт хугацаат санхүүжилтын олдоц хангалттай бусын нөлөөгөөр нэмэгдсэн өөрийн өмчөө эргэлтийн бус хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулан хөрвөх чадваргүй болгодог байдал ажиглагдаж байна.

Ажиллагчдын тоо, хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн судалгаа

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин нь төр засгийн үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй бодлогоос хамаардаг. Төр засгийн үндсэн хоёр үүрэг нь хамгаалах болон бүтээх. Төр засгийн бүтээх үүргийн бодлого юунд төвлөрснөөс хамаарч улс орнууд адилхан хугацаанд, ялгаатай

хөгжлийн түвшинд хүрсэн байдаг. Харилцан адилхан хугацаа, нөхцөлд атлаа харьцангуй хурдан хөгжсөн орнуудын төр засгийн бодлого бүтээмжид суурилдаг болохыг Харвардын их сургуулийн судлаачид тогтоожээ. Энэ судалгааны үр дүн нь үндэстний баялаг, ард түмний амьдралын түвшин нь тухайн орны байгалийн баялаг, хямдхан хөдөлмөрийн хүч, хөрөнгө мөнгөний хэмжээгээр биш, харин бүтээмжээр тодорхойлогддог гэсэн дүгнэлт юм.

Эндээс бүтээмж нь улс орны хөгжил дэвшилтэй холбоотой үзүүлэлт болох нь илэрхий. Бүтээмжийг эдийн засгийн үзүүлэлт буюу орцын нэгжид ногдох гарцын үр дүн гэсэн хандлага нөгөө талаасаа бүтээмж нь нийгэмд хуримтлагдсан мэдлэгийг бүтээлчээр ашиглан баялаг бүтээх буюу нийгэм, эдийн засгийн хүрээг хамарсан өргөн ойлголт гэсэн 2 хандлага байдаг.

Эдийн засгийн онолд хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт нь цалингийн өсөлтийн шалтгаан болдог буюу хөдөлмөрийн бүтээмж нь цалинд нөлөөлдөг гэсэн хандлага байдаг. Энэ ч утгаараа олон улсын түвшинд ихэнх судалгаа материалуудад хөдөлмөрийн бүтээмжийн өөрчлөлт нь бодит цалин ба амьжиргааны түвшинд нөлөө үзүүлдэг талаас нь судалсан байдаг.

Гэтэл нөгөө талаасаа цалингийн өсөлт нь хөдөлмөрийн бүтээмжийн шалтгаан байх онолын боломжийг өсгөсөн судалгаанууд цөөнгүй байдаг. Чилийн “Pontifica”-ийн их сургуулийн зөвлөх профессор А.Marquetti АНУ-ын эдийн засгийн 1869-1996 оны мэдээлэл, 1965-1990 оны 38 орны мэдээллийг (panel) ашиглан цалин болоод хөдөлмөрийн бүтээмжийн урт хугацааны хамаарлыг Коинтэгрэшн болон Гранжерийн шалгууруудыг ашиглан үнэлсэн. Судалгааны үр дүнгээр АНУ болон 38 улсын хувьд хөдөлмөрийн бүтээмж болон цалингийн хооронд урт хугацааны хамаарал байгааг харуулсан. “Vector Error Correction” загвараар бодит цалин нь хөдөлмөрийн бүтээмжийн шалтгаан, харин хөдөлмөрийн бүтээмж нь бодит цалингийн шалтгаан биш гэсэн дүгнэлтэд хүрчээ.

“Бүтээмж нь эдийн засгийн систем (үндэсний эдийн засаг, салбар, байгууллага, аж ахуйн нэгж)-ийн цаг хугацааны тодорхой үед бий болгосон гарцыг, түүнд зарцуулсан орцод харьцуулсан харьцаагаар тодорхойлогдон, эдийн засгийн үндсэн асуудал аль түвшинд хэр зэрэг үр дүнтэй шийдвэрлэгдэж байгааг илтгэх үр ашгийн нэгтгэсэн үзүүлэлт мөн”.

Бүтээмж-нийгэм болоод эдийн засгийн ойлголт болох талаас нь авч үзвэл “Бүтээмж гэдэг нь нийгэмд хуримтлагдсан мэдлэгийг бүтээлчээр ашиглах үндсэндээр хүмүүсийн байнга өөрчлөн сайжруулах хүсэл эрмэлзлэлийг урамшуулан дэмжих орчин нөхцлийг бүрдүүлэн, өөрчлөлтөнд зохицоход чиглэгдсэн удирдлагын тасралтгүй үйл ажиллагаагаар дамжин хэрэгжих, эдийн засгийн гол субъектүүд (үйлдвэрлэгч, хэрэглэгч) харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан нийгэм эдийн засгийн зорилгод хүрэх баялгийг бүтээх үйл ажиллагааг хамарсан цогц ойлголт, түүний хэрэгжилтийн хэмжүүр мөн”.

Бүтээмж дээшилбэл ард түмний амьжиргааны түвшин сайжирч, инфляцийн түвшин буурч, өрсөлдөх чадвар өсдөг нөлөөтэй. Аливаа зүйлийг бүтээхийн тулд түүнд зарцуулж байгаа орц буюу нөөцийг хамгийн боломжтой хэмжээгээр багасгаж, гарцын хэмжээ буюу шинэ баялгийг дээд зэргээр нэмэгдүүлсэнээр бүтээмж өсдөг. Түүнчлэн нэрт эдийн засагч П.Самуэльсон улс орнуудын хоцрогдол, буурай хөгжлийн нэг шалтгааныг бүтээмжийн түвшин доогуур байгаатай холбон тайлбарласан байдаг. Тэрээр бүтээмжийн

Хүснэгт 4. ДНБ, орлогын бүрэлдэхүүнээр, оны үнээр

	2015	2016	2017
ДНБ	23,150.4	23,942.9	27,895.5
• Ажиллагчдын цалин хөлс	6,248.6	6,599.6	7,463.5
• Үндсэн хөрөнгийн хэрэглээ	1,950.0	2,236.5	2,576.0
• Үйлдвэрлэл импортын цэвэр татвар	1,979.0	2,079.0	2,654.9
• Ашиг/холимог орлого, цэвэр	12,972.8	13,027.8	15,201.1
Дүнд эзлэх хувь	100.0	100.0	100.0
• Ажиллагчдын цалин хөлс	27.1	27.6	26.8
• Үндсэн хөрөнгийн хэрэглээ	8.4	9.3	9.2
• Үйлдвэрлэл импортын цэвэр татвар	8.5	8.7	9.5
• Ашиг/холимог орлого, цэвэр	56.0	54.4	54.5

Эх сурвалж: Судлаачийн тооцооноор

түвшин доогуур байх нь ашиг орлого, хуримтлалын хэмжээг бууруулан, улмаар капиталын хөрөнгө оруулалт хийж техник, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг хязгаарлах бөгөөд энэ нь эргээд бүтээмжийг бууруулахад хүргэдэг гэж үзсэн байна. Үүний улмаас буурай хөгжилтэй орнууд ядуурлын “Чөтгөрийн тойрог”-т эргэлдсээр байдаг бөгөөд үүнээс гарах нэг арга зам бол бүтээмжийг дээшлүүлэх явдал мөн гэжээ.

Ядуу орнуудад нэг хүнд ноогдох орлого бага байдаг нь хэмнэх, хуримтлуулах боломжийг хязгаарладаг. Үүний үр дүнд хөдөлмөрийн бүтээмж, орлого бага байдаг. Мөн хүн амын түргэн өсөлт нэг хүнд ноогдох орлогын өсөлтийг үгүй болгож “Чөтгөрийн тойргоос” гарах боломжгүй болгодог. Иймээс бүтээмжийн онол арга зүйг судалж, бүтээлчээр нэвтрүүлэх, түүний өсөлтийг хангах явдал буурай хөгжилтэй орнуудын тоонд ордог манай улсын хувьд бүр ч илүү ач холбогдолтой юм.

ДНБ-ий орлогын арга нь анхдагч орлогуудын нийлбэр буюу бараа, үйлчилгээний дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнээс бий болсон ашиг болон орлогоос бүрдэнэ. Орлогын аргаар тооцсон

ДНБ оны үнээр 2017 онд 27.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос ажиллагчдын цалин хөлс 9.9 хувь, үндсэн хөрөнгийн хэрэглээ 15.2 хувь, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар 27.7 хувь, үйл ажиллагааны ашиг, холимог орлого 18.3 хувиар тус тус нэмэгдсэн байна (Хүснэгт 4).

ДНБ-ий өсөлтөд үйл ажиллагааны ашиг болон ажиллагчдын цалин хөлс голлох байр суурийг эзэлж байна. Орлогын аргаарх ДНБ 2012 онд өмнөх оноос 26.7 хувиар нэмэгдэхэд үйл ажиллагааны ашиг 23.8 хувь, ажиллагчдын цалин хөлс 39.5 хувь нэмэгдсэн нь нөлөөлж байсан бол 2017 оны 16.5 хувийн өсөлтөд үйл ажиллагааны ашиг 16.7 хувь, ажиллагчдын цалин хөлс 13.1 хувь нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Ажиллагчдын цалин хөлс, үйл ажиллагааны ашиг дүнгээрээ ДНБ-ий өсөлтийн 77 хувийг бүрдүүлж байна. Ажиллагчдын цалин хөлс нь ДНБ-ий орлогын 2 дахь том бүрэлдэхүүн бөгөөд 2017 оны гүйцэтгэлээр ДНБ-ий 26.8 хувийг эзэлж байна (Хүснэгт 4).

Ажиллагчдын цалин хөлсний ДНБ-д эзлэх хувь хэмжээний өөрчлөлт нь эдийн засгийн удаашралтай үед өссөн, эдийн засгийн өсөлтийн үед буурсан (урвуу) хандлагатай байдаг.

Хүснэгт 5. Гарц, орц болон хөдөлмөрийн бүтээмж, 2010-2017

	ДНБ (гарц)		Ажиллагчид (хөдөлмөр, орц)		Нэг ажиллагчид ногдох ДНБ	
	Индекс	Өсөлт, %	Индекс	Өсөлт, %	Индекс	Өсөлт, %
2010	100.0		100.0		100.0	
2011	118.8	17.2	100.4	0.4	118.3	16.8
2012	134.5	12.4	102.2	1.8	131.6	10.7
2013	151.0	11.6	106.8	4.4	141.4	7.2
2014	163.1	7.7	107.5	0.6	151.8	7.1
2015	166.1	1.8	111.4	3.6	149.1	-1.8
2016	167.9	1.1	111.0	-0.3	151.2	1.4
2017	177.0	5.3	119.8	7.6	147.7	-2.3

Эх сурвалж: МУ-ын Үндэсний Статистикийн Хороо: "ДНБ, Хөдөлмөрийн бүтээмж-2017 онд" судалгаа

Хүснэгт 6. Хөдөлмөрийн бүтээмж, орц, гарцын жилийн өөрчлөлт, хувиар, 2017

Салбарууд	Хөдөлмөрийн бүтээмж	Нэмэгдэл өртөг	Ажиллагчдын тоо
ХАА	0	2.3	2.3
Уул, уурхай олборлолт	-37.9	-7.1	30.8
Боловсруулах	11.6	19.4	7.8
Цахилгаан, хий, уур	-3.5	4.2	7.7
Усан хангамж	23.2	2.9	-20.3
Барилга	-1.1	-2.3	-1.1
Бөөний жижиглэн худалдаа	-7.3	9.6	16.9
Тээвэр	3.9	13.7	9.8
Байр, сууц, хоол хүнсээр үйлчлэх	-5.8	6.7	12.6
Мэдээлэл холбоо	35.8	13.6	-22.2
Санхүү, даатгал	-1.9	7.7	9.6
Бусад	-17.3	1.7	19

Эх сурвалж: МУ-ын Үндэсний Статистикийн Хороо: "ДНБ, Хөдөлмөрийн бүтээмж-2017 онд" судалгаа


Цалин хөлс нь үйлдвэрлэлийн зардлын гол бүрэлдэхүүн бөгөөд цалин хөлсний ДНБ-д эзлэх хувь хэмжээ өсөж байгаа нь цалин хөлс ашгаас илүү хурдан өсөж байгааг эсвэл ашиг буурч байгааг илэрхийлдэг.

Нийт эдийн засгийн хувьд бүтээмжийг нэг ажиллагчид ногдох ДНБ-ийн хэмжээгээр илэрхийлнэ. Бүтээмжийн өсөлтийг гарц болон орцын өсөлтийн зөрүүгээр тооцно. Нэг хүнд ногдох ДНБ (2010 оны зэрэгцүүлэх

үнээр) 2017 онд 5.4 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 2.7 хувиар өссөн бол нэг ажиллагчид ногдох ДНБ 13.0 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 2.3 хувиар буурчээ.


Хөдөлмөрийн бүтээмж 2012-2015 онд буурч байсан бол 2016 онд өмнөх оноос 1.4 хувиар нэмэгдсэн ч 2017 онд өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар буурчээ (Хүснэгт 5). ДНБ өссөнөөр хөдөлмөрийн бүтээмж 5.3 хувиар өссөн бол, ажиллагчдын тоо

Зураг 5. Нэмэгдэл өртөг, ажиллагчдын тоон өөрчлөлт, хувиар



Тайлбар: 1 - ХАА; 2 - Уул уурхай, олборлолт; 3 - Боловсруулах; 4 - Цахилгаан, хий, уур; 5 - Усан хангамж; 6 - Барилга; 7 - Бөөний жижиглэн худалдаа; 8 - Тээвэр; 9 - Байр, сууц, хоол хүнсээр үйлчлэх; 10 - Мэдээлэл холбоо; 11 - Санхүү, даатгал; 12 - Бусад

Зураг 6. Хөдөлмөрийн бүтээмжийн өөрчлөлт, хувиар



Тайлбар: 1 - ХАА; 2 - Уул уурхай, олборлолт; 3 - Боловсруулах; 4 - Цахилгаан, хий, уур; 5 - Усан хангамж; 6 - Барилга; 7 - Бөөний жижиглэн худалдаа; 8 - Тээвэр; 9 - Байр, сууц, хоол хүнсээр үйлчлэх; 10 - Мэдээлэл холбоо; 11 - Санхүү, даатгал; 12 - Бусад

өссөнөөр хөдөлмөрийн бүтээмж 7.6 хувиар буурчээ.

Хүснэгт №6-аас хөдөлмөрийн бүтээмж 2017 оны гүйцэтгэлээр бизнесийн секторын нийт 12 салбараас 5 салбарт өсөлттэй, 7 салбарт бууралттай гарчээ. Харин гарц 10 салбарт, орц буюу ажиллагчдын тооны хувьд 9 салбарт өсөлт гарсан байна.

Санхүү даатгалын салбарын бүтээмж 1.9 хувийн бууралттай, гэхдээ гарц (7.7%) болон орц (9.6%) аль аль нь өссөнийг илэрхийлж байна. Мэдээлэл холбооны салбарт хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөр өсөлттэй (35.8%) байна. Энэ нь гарц 13.6 хувиар нэмэгдэж, орц 22.2 хувиар буурсантай холбоотой юм.

Харин хөдөлмөрийн бүтээмж хамгийн их бууралттай (-37.9%) уул уурхай, олборлох салбарын хувьд орц 30.8 хувиар нэмэгдсэн ч гарц 7.1 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Дүгнэлт

Монгол улсад үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн тоо жилээс

жилд дунджаар 5-11 хувиар нэмэгдэж байна. 2018 оны 2-р улирлын байдлаар нийт 163,100 ААНБ бүртгэлтэй байна. Үүний 83,086 буюу нийт аж ахуйн нэгжийн 51 хувь нь л үйл ажиллагаа явуулж байна. Үлдэж байгаа аж ахуйн нэгжүүд нь (49 хувь) үйл ажиллагаа явуулаагүй, эрхлээгүй, түр зогсоосон, үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна.

2016 оны байдлаар жижиг, дунд аж ахуйн нэгж буюу 100 сая төгрөг хүртэлх хөрөнгө, борлуулалтын орлоготой байгууллагын тоо нийт ААНБ-ын 79-85 хувийг эзэлдэг боловч нийт хөрөнгийн 6 хувийг эзэмшиж, борлуулалтын орлогын 15 хувийг л бүрдүүлж, харин том аж ахуйн нэгжүүд тооны хувьд цөөхөн (14-21%) боловч хөрөнгийн 94%, орлогын 81%-ийг бүрдүүлж тэдгээрийн үүрэг оролцоо сүүлийн 5 жилд тогтвортой нэмэгдэх хандлагатай болжээ. Монгол Улсын ААНБ-уудын санхүүгийн төлөв байдлын он дараалсан мэдээллийн сан бүрдүүлж, тайлангийн нэгтгэлийг салбараар нь гаргах, санхүүгийн тайлангийн мэдээллийг

бодитой, ил тод, нээлттэй байдлыг хангах замаар эргэлтэнд оруулж, санхүүгийн тогтворгүй байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг дотоодын болон хамтарсан, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гэх мэт ангилал тус бүрээр судалж дүгнэлт өгөх, салбарын бодлогыг тодорхойлох шаардлага тавигдаж байна.

ААНБ-ын хүрээнд үндэсний баялаг бүтээгдэж, санхүүгийн анхны хуваарилалт хийгддэг ААНБ-ын санхүүгийн төлөв байдал нь эдийн засгийн тогтворжилтын суурь үндэс болно. Гэтэл манай аж ахуйн нэгжүүд хэт жижиг, хувьцаат компани цөөн, төрөлжиж хоршоогүй учраас менежментийн сонгодог арга хэлбэрүүд нэвтэрч үр дүнгээ өгөхгүй байна. Нөөц баялгийг зүй зохистой, үр ашигтай хуваарилан зарцуулах үйл ажиллагааг өрсөлдөхүйц түвшинд хүргэн оновчтой зохион байгуулж, бүтээмжийн өсөлтийг хангах нь аливаа улс орон, бизнесийн байгууллагын өрсөлдөх чадварын үндсэн хэмжүүр юм. Монгол Улсын засгийн

газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогыг бүх салбарт баримтална гэж тусгажээ. Манай улсын хувьд эдийн засгийн тогтвортой байдлыг харуулах инфляцийн түвшин тогтворгүй, өсөлттэй байгаа. Ажиллагчдын хөдөлмөрийн бүтээмж өсөөд цалин нэмэгдсэн ч нөгөө талаас бараа бүтээгдэхүүний үнэ өссөнөөр бодит цалинд өөрчлөлт төдийлөн ордоггүй. Иймд төрийн эдийн засгийн бодлого, мөнгөний бодлого нэгдмэл байж хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх, цалинтай нь уялдуулах тухай авч үзэх ёстой.

Олон улсын түвшинд хөдөлмөрийн бүтээмжийг тооцох аргачлалын дагуу хөдөлмөрийн хүн цаг, хүн өдөр, цаг ашиглалт зэрэг нарийвчилсан үзүүлэлтүүдийг тооцон гаргах төдийгүй ААНБ бүр бүтээмжийг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Сайнжаргал, Б. (1999). *Санхүүгийн тайлангийн шинжилгээ*. Улаанбаатар.
2. Оюунцэцэг, Л. (2004). *Бүтээмжийн менежментийн онол арга зүйн асуудал*. Улаанбаатар.
3. Савицкая, Г. В. (2017). *Методика комплексного анализа хозяйственной деятельности*. Москва.
4. Podkaminer, L. (2017). Labor Productivity Growth Slowdown: An Effect of Economic Stagnation rather than Its Cause?. *Acta Oeconomica*, 67(s1), 67-77.
5. Enkhsaikhan, S. (2012). *Management of Productivity of the State*. Ulaanbaatar, KITON Printing, 126-130.
6. http://www.tuv.nso.mn/uploads/users/87/files/GDP_buteemj_2017.pdf
7. <http://mof.gov.mn>
8. <http://1212.mn>